

Нутаг буцахад үзүүлэх туслалцаа

- Зөвлөгөө өгөх
- Нутаг руугаа буцах аялалыг зохицуулах
- Санхүүгийн тусламж
(насанд хүрэгсэд CHF 1000.-; хүүхэд CHF 500.-)
- Эрүүл мэндийн туслалцаа болон эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусгай үйлчилгээ
- Бизнесийн төсөл
- Сургалтын хөтөлбөр
- Орон байраар туслах

Нутаг буцахад үзүүлэх туслалцаа гэж юу вэ?

Нутаг буцахад үзүүлэх туслалцаа нь бол эх нутагтаа эргэн очсоноор авах тусламж юм. Энэ нь амьдралаа шинээр эхлэн, эх нутагтаа эргэн амжилтай суурьшихад тань дэм болох учиртай.

Хэнд энэ туслалцааг үзүүлэх вэ?

Орогнол хүссэн хүмүүс болон бусад ангилалд багтах гадаадын иргэд (жишээ нь, хүний наймааны хохирогчид).

Улс төрийн цагаач статустай байлаа ч гэсэн та энэ тусламжийг авах боломжтой байж болно.

Хэзээ ба хэрхэн авах вэ?

Орогнол хүсэх явцдаа юмуу эсвэл түүний дараа аль ч үед энэхүү тусламж авах хүсэлтийг гаргаж болно. Бусад ангилалд багтах гадаадын иргэдийн хувьд тусгай дүрэм байдаг.

Нутаг буцахад өгөх зөвлөгөө гэж юу вэ?

Энэ зөвлөгөө нь нутаг буцахад үзүүлэх тусламжийн талаарх мэдээлэл өгөх үйлчилгээ юм.

Зөвлөгөө авсан хэдий ч заавал буцах албагүй бөгөөд яригдсан зүйлийн нууцыг чанд хадгална.

Шийд нь гараагүй байгаа орогнол хүссэн өргөдөлд огт нөлөөлөхгүй. Нутаг буцах бэлтгэлээ хангаж, зохицуулахад тань туслах учиртай.

Энэ зөвлөгөөг хаанаас авч болох вэ?

Швейцарийн кантон бүр нутаг буцахад зөвлөгөө өгдөг үйлчилгээтэй. Эдгээрийн хаяг, утасны дугаарыг дараахь хуудаснаас үзнэ үү.